

**ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ
ОРШИХ “ХӨХ ДЭЛ”-ийн ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ
АШИГЛАХ ТӨСЛИЙН 2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

*Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар: MV-004487
Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар: 2550466*

Хянасан:

БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын
газрын мэргэжилтэн

...../П.ШИНЭЦЭЦЭГ/

Хэрэгжилтийг гаргасан:


“Монголросцветмет” ТӨҮГ-ын захирал

...../Б.МӨНХБАТ/

Боловсруулсан:

БО, НС хариуцсан ерөнхий мэргэжилтэн

...../Д.ОЮУНСАЙХАН/



Улаанбаатар хот
2022 он

АГУУЛГА

БҮЛГИЙН ДУГААР	АГУУЛГЫН ГАРЧИГ	ХУУДАСНЫ ДУГААР
БҮЛЭГ 1	ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	
1.1	Төслийн ерөнхий мэдээлэл	4
1.2	Ордын тухай товч мэдээлэл	7
1.2.1	Ордын физик газарзүй	8
1.3	Ил уурхайн олборлолт	8
1.3.1	Ил уурхайн хүрээ	8
1.3.2	Үйлдвэрлэлийн нөөц, 2022 оны олборлолт	8
1.3.3	Хүдрийн хаягдал, бохирдлын тооцоо	9
1.4	Үйлдвэрийн хүчин чадал, ажиллах горим	12
1.5	Дэд бүтэц	12
1.5.1	Цахилгаан хангамж	12
1.5.2	Усан болон дулаан хангамж	13
1.5.3	Барилга байгууламж	13
БҮЛЭГ 2	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	
2.1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	14
2.2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	22
2.3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	24
2.4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	27
2.5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	28
2.6	Болзошгүй эрсдлээс хамгаалах менежментийн төлөвлөгөөний биелэлт	28
2.7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	26
2.8	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	38
2.9	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөөний биелэлт	34
2.10	Тухайн жилийн БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	45
-	ХАВСРАЛТ МАТЕРИАЛ	

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	ХУУДАС
Хүснэгт 1. “Хөх дэл”-ийн уурхайн тусгай зөвшөөрөлтэй талбайн газар зүйн солбицол	4
Хүснэгт 2. “Зүүн үнэгт” хайлуур жоншны ил уурхайн үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо	10
Хүснэгт 3. Уурхайн ажиллах горим	12
Хүснэгт 4. Баяжуулах цехийн ажлын горим	12
Хүснэгт 5. 2022 оны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	15
Хүснэгт 6. 2022 оны техник болон биологийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	22

Хүснэгт 7. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	24
Хүснэгт 8. Болзошгүй эрсдлээс хамгаалах төлөвлөгөөний биелэлт	28
Хүснэгт 92. Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний биелэлт	31
Хүснэгт 10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	38
Хүснэгт 11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	42
Хүснэгт 12. Тухайн жилийн БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваар	45

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

ЗУРГИЙН ЖАГСААЛТ	ХУУДАС
Зураг 1. “Хөх дэл”-ийн хайлуур жоншны ордын байрзүйн зураг	4
Зураг 2. “Хөх дэл”-ийн хайлуур жоншны ордын байршлын тойм зураг	5
Зураг 3. “Хөх дэл”-ийн хайлуур жоншны ордын байршлын зураг	6
Зураг 4. Тоосжилт дарах зорилгоор зам арчилгаа хийсэн байдал	18
Зураг 5. Хурдны хязгаарлах тэмдэг байрлуулсан байдал	19
Зураг 6. Шатах тослох материалын хадгалалтыг сайжруулсан байдал	19
Зураг 7. Авто тээврийн хэрэгслүүдийг үзлэгт хамруулсан байдал	19
Зураг 8. Ажилчдын байдал ХХАА-ны хувцас хэрэглэл	20
Зураг 9. Гүний худагт суурилуулсан тоолуур	20
Зураг 10. Уурхайн карьерт мал, амьтан унахаас сэргийлж нүхийг тойруулан овоолго үүсгэсэн байдал	20
Зураг 11. Шувууны үүр хийж байрлуулсан байдал	21
Зураг 12. Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайн зураг	22
Зураг 13. Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайн зураг	23
Зураг 14. Техникийн нөхөн сэргээлт хийж овоолгуудыг тэгшилсэн байдал	24
Зураг 15. Хайлаас мод тарьж буй байдал /уурхайн кемп дэх талбайд/	25
Зураг 16. Хайлаас мод тарьж буй байдал /уурхайн кемп дэх талбайд/	25
Зураг 17. Хайлаас мод тарьж буй байдал /уурхайн гол зам дагуу/	26
Зураг 18. Хайлаас мод тарьсан байдал	27
Зураг 19. Болзошгүй эрсдэл болон аюул ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор ажилчдад сургалт зохион байгуулж буй зураг	29
Зураг 20. Аюултай хог хадгалах байр	33
Зураг 21. 00-ыг сайжруулсан байдал	33
Зураг 22. Ариутгал, халдваргүйжүүлэх ажил хийгдэж буй байдал	34
Зураг 23. Ахуйн бохир усыг түр хадгалах цооног	34
Зураг 24. Ахуйн хог хаягдлыг ангилан хаях хогийн сав	35
Зураг 25. Хог хаягдлыг гэрээ	36
Зураг 26. Хог хаягдлын төлбөр төлсөн баримт	37
Зураг 27. Байгаль дэлхийгээ хайрлах талаар ухуулга самбар байрлуулсан байдал	39
Зураг 28. Аюулгүй ажиллагааны самбар байрлуулсан байдал	40
Зураг 29. 2022 оны ус ашиглуулах дүгнэлт	49
Зураг 30. Ус ашиглуулах зөвшөөрөл	50
Зураг 31. Ус ашиглах гэрээ	52
Зураг 32. Хаягдал усны дүгнэлт	55
Зураг 33. Усны төлбөр төлсөн баримт	54
Зураг 34. Агаарын шинжилгээний хариу	57

“Монголросцветмет” ТӨҮГ-ын Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт байрлах “Хөх дэл”-ийн хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах төслийн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Зураг 35. Усны шинжилгээний хариунууд	59
Зураг 36. Хөрсний хүнд элементийн дээжийн хариунууд	61
Зураг 37. Галын аюулгүй байдлын дүгнэлт	52
Зураг 38. Авто тээврийн хэрэгслүүдийг үзлэгт хамруулсан байдал /бүх тээврийн хэрэгсэл/	67
Зураг 39. 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг сум, нөлөөллийн бүсийн айлд тайлагнасан байдал	69

БҮЛЭГ I. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн ерөнхий мэдээлэл


Төслийн нэр : “Хөх дэл” нэртэй хайлуур жоншны ордыг ил уурхайн аргаар ашиглах төсөл

Төсөл хэрэгжүүлэгч: “Монголросцветмет” ТӨҮГ, Улсын бүртгэлийн дугаар: 9019029071, Регистрийн дугаар: 2550466, Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар: 92.5 гектар бүхий “Зүүн үнэгт” нэртэй MV-004487 талбай


Төслийн байршил: Хөх дэлийн жоншны орд нь Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт оршино. Төслийн талбай нь Баянжаргалан сумын төвөөс урагш 35 км, аймгийн төв Мандалговиос 150 км, Бор-Өндөр УБҮ-ийн төмөр замаас 170км-т байрлана.

Хүснэгт 1. “Хөх дэл”-ийн уурхайн тусгай зөвшөөрөлтэй талбайн газар зүйн солбицол


Тусгай зөвшөөрлийн дугаар	Цэгийн дугаар	Өргөрөг			Уртраг			Талбайн хэмжээ, га
MV-004487	1	45 ⁰	30'	58.62"	107 ⁰	59'	08.49"	92.5
	2	45 ⁰	30'	58.62"	107 ⁰	58'	22.5"	
	3	45 ⁰	30'	41.62"	107 ⁰	58'	22.5"	
	4	45 ⁰	30'	41.62"	107 ⁰	58'	45.51"	
	5	45 ⁰	30'	15.62"	107 ⁰	58'	45.51"	
	6	45 ⁰	30'	15.62"	107 ⁰	59'	08.49"	



Зураг 1. “Хөх дэл”-ийн хайлуур жоншны ордын байрзүйн зураг



Зураг 2. “Хөх дэл”-ийн хайлуур жоншны ордын байршлын тойм зураг



Зураг 3. “Хөх дэл”-ийн хайлуур жоншны ордын байршлын зураг

1.2 Ордын тухай товч мэдээлэл

1.2.1 Ордын физик газарзүй

Уул зүй. Тус төслийн талбай нь далайн түвшинээс дээш 1241,0-1321,1 м үнэмлэхүй өндөрт өргөгдсөн, 80,1 м харьцангуй өндөр бүхий хагас цөлийн бүсийн тэгш тал, жижиг толгодорхог гадаргуу бүхий нутаг юм.

Төслийн талбайн ойр орчимд Залаагийн хяр, Тооройн хяр, Ханын хэц, Тэвшийн хяр, Тахилга уул Залаа хайрхан уул, Давч уул зэрэг зүүн урд талаараа Сайншандын уул Борхойн уул, Далан уул, Өлзийт, Могойтын дэл, Их шанхын нуруу, Зараа толгой, Цэцийн уул зэрэг уул нурууд гадаргын онцлогийг бүрдүүлдэг Тэдгээр уулс нь голлон өргөрөгийн дагуу чиглэлтэй, тэдгээрийн хоорондын хөндийд жижиг нуур цөөрөм бүхий тал болон жижиг толгодорхог хэсэг байрлажээ.

Хөрс. Тус талбай нь говь, хээрийн бор хөрсний бүсэд багтдаг. Энэ бүс нутагт хөрсний бүрхэвч үүсэж, хөгжихөд хур тунадас, салхи ихээхэн үүрэг гүйцэтгэжээ. Салхи нь хөрсний агаарын солилцоог идэвхжүүлж ууршилтыг ихэсгэснээр хөрс хуурайшихад нөлөөлөөд зогсохгүй хөрсний өнгөн хэсгийг хийсгэж нүүлгэн хөрс эвдэгдэхэд ихээхэн нөлөөтэй. Хур бороо элбэг үед ургамлын бүрхэвч эрс сайжирч хөрсний эвдрэл үүсэх нөхцлийг багасгана. Тэгш өндөрлөг газруудад бор саарал, саарал хөрс, зонхилж, хайрга чулуун хуягаар зарим газраа бүрхэгдэнэ. Хонхор хотгор газруудаар хужир тойром, мараалаг хөрс элбэг тархана. Талбайн зарим хэсгүүдэд элсэрхэг хөрс зонхилдог.

Ургамал. Төслийн талбай нь хойд говийн цөлөрхөг хээрийн мужийн говирхог хээр боловч баглуур өвс-таанат, баглуур өвст-бударганат хээрийн бүсэд багтдаг. Тус бүсэд ус чийг харьцангуй бага, салхитай өдрийн тоо харьцангуй олон учир ургамлын бүрхэвч сийрэгдүү байдаг онцлогтой. Бэлчээрийн гол хэсэг нь говийн хэсэгт таана, хөмүүл, шарилж монгол өвс зонхилж байхад уулын хяраар хялгана хиаг зээргэнэ, зэрлэг сонгино болон хонин зээргэнэ зэрэг ургамал ургадаг, Уулын ам, хөндий гуу, жалга бараадан бутлаг ба модлог ургамал, сухай, харгана, бударгана ургана. Ургамлын бүрхэвч ерөнхийдөө сийрэг боловч бэлчээрийн тэжээллэг чанар ихтэй учир хөдөө аж ахуйд ач холбогдол ихтэй.

Амьтны аймаг. Тус бүс нутагт дархан цаазтай амьтадаас аргаль, янгир, хар сүүлт, туурайтаас намрын цагт цагаан зээр нүүдэллэн ирдэг. Жигүүртнээс элээ, хэрээ, тас, харцага, тогоруу, ногторуу, шаазгай, шар шувуу, ууль, тагтаа, хэвлээр явагчидаас могой, гүрвэл, мэрэгчидээс үлийн цагаан, шар сүүлт, алаг даага, махчин амьтадаас чоно, үнэг, хярс, мануул, шавьж идэштнээс зараа суурьшин амьдардаг.

Уур амьсгал. Ерөнхийдөө уур амьсгалын хувьд гандуу зунтай, хүйтэн өвөлтэй байх тохиолдол давмгайлдаг ба сүүлийн жилүүдэд энэ дүр зураг улам нэмэгдэж байгаа. Жилийн хамгийн их хүйтрэл нь I сард -35°C , хамгийн халуун нь VII сард $+35^{\circ}\text{C}$ хүрдэг. жилийн дундаж температур $2-4^{\circ}\text{C}$ ажээ. Агаарын харьцангуй чийгшил нь I сард хамгийн их 50-60%, VII сард хамгийн бага буюу $<40\%$ -иас байдаг. Жилд унах тунадас дунджаар 100-150 мм байдаг ба ус чийг багатай тул манан будан ажиглагдахгүй. Тус бүсэд голлон баруун хойноос салхилах салхи хоногийн хэлбэлзэл ихтэй. Жилийн дунджаар салхигүй өдрийн

тоо 20-25 хоног юм. Хаврын улирал хамийн их салхитай ба энэ үеэр цасан болон шороон шуурга шуурдаг. Жилийн салхины дундаж хурд 5-10 м/сек, дунджаар 32-39 хоног (ихэнх нь хавар) 15 м/с хүртэл хүчтэй цасан болон шороон шуурга шуурдаг. Хамгийн дээд тал нь 40 м/с хүрдэг тохиолдол байдаг ажээ.

Эдийн засаг, хүн ам, зам харилцаа. Төслийн талбай нь дэд бүтэц харьангуй сул хөгсөн, хүн ам сийрэг суурьшсан бүс нутаг юм. Улсын чанартай төв зам төслийн талбайгаас хол өнгөрдөг ба орон нутгийн чанарай шороон замуудаар ойролцоох сумын төвүүдтэй холбогдоно. Нутгийн оршин суугчид нь халх ястан аж төрдөг. Хүн амын гол хөдөлмөр нь мал аж ахуй бөгөөд 5 хошуу малыг бүгдийг нь өсгөдөг онцлогтой. Гэвч сүүлийн жилүүдэд сүргийн бүтцийн дийлэнх хэсгийг бог мал, тэр дундаа ямаа эзэлж байгаа нь малын бэлчээрт муугаар нөлөөлж байгаа муу мэдээ байдаг. Сүүлийн жилүүдэд өвлийн улиралд зуд турхан болох нь нэмэгдэж байгаатай холбогдуулан орон нутгийн малчид өвөл, хавартаа бусад аймаг, бүс нутагт оторлон нутаглах нь эрс нэмэгдэж байгаа.

Сумын төв нь орон нутгийн чанартай шороон замаар холбогдох ба эмнэлэг, сургууль, харилцаа холбоо болон хувийн хэвшлийн үүрэн телефоны операторууд, ХААН, Хадгаламж банкны салбар, Петровис компаний болон бусад ШТС-ууд, хүнс, барааны дэлгүүр, зочид буудал үйл ажиллагаа явуулдаг. Сумын төвүүд нь бүгд өндөр хүчдэлийн шугаманд холбогдсон байдаг.

Талбай нь нийслэлээс алслагдсан эдийн засаг, дэд бүтэцийн хөгжил сул бүсэд хамаарах боловч бүс нутгийнхаа хэмжээнд дэд бүтэцийн хөгжил харьцангуй сайжирсанд тооцогддог.

1.3. ИЛ УУРХАЙН ОЛБОРЛОЛТ

1.3.1. Ил уурхайн хүрээ

Ил уурхайн аргаар ашиглалт явуулахад хүдрийн биет унал, зузаан, гүн зэрэг үзүүлэлтээс шалтгаалан ил уурхайн ашиглалтын хүрээг оновчлох шаардлага гардаг. Зүүн үнэгт ордын талбай нь ерөнхийдөө дов толгодорхог газар болно. Газрын гадаргуугийн өндөржилт +1150 -1170 м байна. Тус ордын 1, 2, 4, 5, 6-р хүдрийн биетийн зузаан нь 2.5-3.1 м, уналын өнцөг 62 - 65⁰ байна.

Уурхайн хажуугийн тогтворжилт: Чулуулгийн шахалтын бат бөх $\delta_{ш} > 80$ МПа, Уурхайн гүн < 90 м энэ үзүүлэлтүүдэд үндэслэн уурхайн тогтвортой хажуугийн өнцөг 50-60⁰ байна гэж үзлээ. Уг уурхайн бодит өнцөг нь 45-55⁰ байгаа нь энэ нөхцлийг хангаж байна. Уурхайн хажуугийн өнцөг нь “Гапроруда”-ийн баримтлал (Инженерийн лавлах 5, ХУ-82) - аар тогтвортой байхаар байна.

1.3.2. Үйлдвэрлэлийн нөөц, 2022 оны олборлолт

Ил уурхайд хүрээнд хамаарах геологийн нөөцийг олборлохын тулд дээрх тооцооны дагуу хаягдал, бохирдол үүснэ. Энэхүү нөөцөнд тулгуурлан Уул уурхайн сайдын 2015 оны 09-р сарын 11-ний өдрийн 203 тоот “Ангилал, заавар батлах тухай” тушаалыг үндэслэн ордын үйлдвэрлэлийн нөөцийн тооцоог хийж дараах хүснэгтэд харууллаа. Ил уурхайн хүрээнд өртөх болон хүрээний гадна үлдэх нөөцийн тооцоог түвшингээр ялгаж харууллаа.

1.3.3. Хүдрийн хаягдал, бохирдлын тооцоо

Аливаа ашигт малтмалыг газрын хэвлийгээс олборлон гаргахад одоогийн техник, технологийн түвшинд бодит нөөцийг бүрэн хэмжээгээр олборлож чаддаггүй. Нөгөө талаас хүдрийн биетийн тогтоц, тухайн ордын уул-геологи, уул-техникийн нөхцөл, ашиглалтын технологи, тектоникийн бүтэц зэргээс шалтгаалж бохирдолт үүсдэг.

Ийм учир геологийн нөөцийн хэмжээ ашиглалтын явцад ямар нэг хэмжээгээр өөрчлөгддөг бөгөөд энэ нь ашиглалтын үеийн хаягдал, бохирдолтой холбоотой байдаг.

Хүснэгт 2. “Зүүн үнэгт” хайлуур жоншны ил уурхайн үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо

№	Нөөцийн блокын зэрэг, дугаар	2022 оны олборлолт /геологийн нөөц/						Ашиглалтын үеийн хаягдал, бохирдол						2022 оны олборлолт /үйлдвэрлэлийн нөөц/					
		Хүдэр олборлолт		Хаягдал, 6.75 %		Бохирдол, 8.8%		Хүдэр олборлолт		Хаягдал, 6.75 %		Бохирдол, 8.8%		Хүдэр олборлолт		Хаягдал, 6.75 %		Бохирдол, 8.8%	
Хэмжих нэгж	Нийт уулын цул, мян.м3	Хөрс, мян.м3	Эзлэхүүнээр, мян.м3	Жингээр, мян.тн	Агуулга, %	Эрдэс, мян.тн	Эзлэхүүнээр, мян.м3	Жингээр, мян.тн	Эрдэс, мян.тн	Эзлэхүүнээр, мян.м3	Жингээр, мян.тн	Эрдэс, мян.тн	Нийт уулын цул, мян.м3	Хөрс, мян.м3	Эзлэхүүнээр, мян.м3	Жингээр, мян.тн	Агуулга, %	Эрдэс, мян.тн	
																			мян.м3
Уурхай - 1																			
1	В-1-1	20.73	18.79	1.93	5.22	36.38	1.90	0.13	0.35	0.13	0.16	0.43	20.73	18.76	1.96	5.30	33.44	1.77	
2	В-1-2	28.39	25.74	2.65	7.15	48.74	3.48	0.18	0.48	0.24	0.22	0.59	28.39	25.70	2.69	7.25	44.79	3.25	
3	В-1-3	2.58	2.34	0.24	0.65	32.95	0.21	0.02	0.04	0.01	0.02	0.05	2.58	2.34	0.24	0.66	30.29	0.20	
4	В-1-4	20.80	18.86	1.94	5.24	46.18	2.42	0.13	0.35	0.16	0.16	0.43	20.80	18.84	1.97	5.32	42.44	2.26	
5	С-1-1	21.66	19.61	2.06	5.45	36.39	1.98	0.14	0.37	0.13	0.17	0.45	21.66	19.58	2.09	5.53	33.45	1.85	
Нийт В+С		94.16	85.34	8.82	23.71	42.18	10.00	0.60	1.60	0.67	0.72	1.95	94.16	85.22	8.95	24.05	38.77	9.32	
Уурхай - 2																			
1	В-2-1	77.00	71.42	5.58	15.07	38.79	5.85	0.38	1.02	0.39	0.46	1.24	77.00	71.34	5.66	15.29	35.65	5.45	
2	С-2-1	85.02	78.86	6.16	16.64	49.39	8.22	0.42	1.12	0.55	0.51	1.37	85.02	78.77	6.25	16.88	45.40	7.66	
Нийт В+С		162.03	150.28	11.74	31.71	44.35	14.06	0.79	2.14	0.95	0.96	2.60	162.03	150.11	11.92	32.17	40.77	13.11	
Уурхай - 4																			
1	В-4-1	16.66	15.45	1.21	3.26	50.57	1.65	0.08	0.22	0.11	0.10	0.27	16.66	15.43	1.22	3.31	46.48	1.54	
2	С-4-1	31.32	29.05	2.27	6.13	49.00	3.00	0.15	0.41	0.20	0.19	0.50	31.32	29.02	2.30	6.22	45.04	2.80	
3	С-4-2	48.61	45.09	3.52	9.51	38.23	3.64	0.24	0.64	0.25	0.29	0.78	48.61	45.03	3.57	9.65	35.14	3.39	
4	С-4-3	18.39	17.06	1.33	3.60	38.23	1.38	0.09	0.24	0.09	0.11	0.30	18.39	17.04	1.35	3.65	35.14	1.28	
Нийт В+С		114.98	106.65	8.33	22.50	42.95	9.67	0.56	1.52	0.65	0.68	1.85	114.98	106.53	8.46	22.83	39.48	9.01	
Уурхай - 5																			

“Монголросцветмет” ТӨҮГ-ын Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт байрлах “Хөх дэл”-ийн хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах төслийн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

5	В-5-1	28.51	25.85	2.66	7.18	25.68	1.84	0.18	0.48	0.12	0.22	0.59	28.51	25.81	2.70	7.28	23.60	1.72
6	В-5-2	12.51	11.34	1.17	3.15	34.48	1.09	0.08	0.21	0.07	0.10	0.26	12.51	11.32	1.18	3.20	31.69	1.01
Нийт В+С		41.01	37.19	3.83	10.33	28.36	2.93	0.26	0.70	0.20	0.31	0.85	41.01	37.13	3.88	10.48	26.07	2.73
Уурхай - 6																		
7	В-6-1	19.49	17.68	1.82	4.91	33.29	1.63	0.12	0.33	0.11	0.15	0.40	19.49	17.65	1.84	4.98	30.60	1.52
8	В-6-2	52.37	47.48	4.89	13.19	53.16	7.01	0.33	0.89	0.47	0.40	1.08	52.37	47.41	4.96	13.38	48.86	6.54
8	В-6-3	27.79	25.20	2.59	7.00	53.16	3.72	0.18	0.47	0.25	0.21	0.57	27.79	25.16	2.63	7.10	48.86	3.47
НийтВ+С		99.66	90.36	9.30	25.10	49.27	12.37	0.63	1.69	0.83	0.76	2.06	99.66	90.22	9.43	25.47	45.29	11.53
Нийт ордын хэмжээнд		511.84	469.82	42.02	113.4	43.25	49.0	2.84	7.65	3.31	3.4	9.3	511.84	469.21	42.63	115.00	39.75	45.7

Дээрх тооцооноос харахад 2022 оны төлөвлөлтөөр 1, 2, 4, 5, 6-р хүдрийн биетүүдэд 469.2 мян.м³ хөрс хуулж, үйлдвэрлэлийн нийт нөөц нь хаягдал ба бохирдол тооцсоноор хүдрээр 115.0 мян.тн болж байна.

1.4. ҮЙЛДВЭРИЙН ХҮЧИН ЧАДАЛ, АЖИЛЛАХ ГОРИМ

Тус ордын 1, 2, 4, 5, 6-р хүдрийг биетийг 2022 онд 115.0 мян.тн хүдэр олборлохоор төлөвлөсөн.

Уурхайн ажиллах горимыг уурхайн хүчин чадал, жилд гүйцэтгэх уулын ажлын хэмжээнээс хамааруулан жилийн 12 сарын турш, 12 цагийн үргэлжлэлтэй 1 ээлжээр ажиллуулахаар төлөвлөв.

Хүснэгт 3. Уурхайн ажиллах горим

№	Үндсэн ажиллагаа	Хэмжих нэгж	Газрын дээр
1	Хуанлийн өдөр (3,15-11,15)	Хоног	365
2	Баяр ёслолын амралт	Хоног	13
3	Цаг агаарын хүндрэл	Хоног	12
4	Жилд ажиллах хоног	Хоног	340
5	Жилд ажиллах цаг	Цаг	8160
6	Хоногт ажиллах ээлж	Ээлж	2
7	Ээлжийн үргэлжлэх хугацаа	Цаг	12

Гар аргаар ангилан ялгах: Төлөвлөлтөөр жилд 60 мян.тн хүдэр олборлохоор тооцсон. Тус ордоос олборлосон хүдрийн гар аргаар ангилан ялгаж ФК-75 маркийн бүхэллэг жонш гаргаж авахаар төлөвлөсөн.

Ашигт эрдэс болон хоосон чулуулгийг өнгө, гялга, хэлбэр дүрсээр нь таньж ялгах процесс юм. Баяжуулалтын бусад аргыг ашиглах боломжгүй нөхцөлд болон баяжмалын чанар шаардлага хангахгүй нөхцөлд уг аргыг ашигладаг.

Гар ялгалтыг жилд 238 хоног, 10 цагаар 1 ээлжээр ажиллахаар тооцсон.

Хүснэгт 4. Баяжуулах цехийн ажлын горим

Д/д	Үзүүлэлт	Хэмжээ
1	Жилд ажиллах хоног	215
2	Хоногт ажиллах ээлж	1
3	Ээлжийн үргэлжлэх хугацаа, цаг	12

Гар аргаар нийт хүдрийн 12.34 %-ийг гарцтайгаар ФК-75 маркийн бүхэллэг жонш ялгана. Үлдсэн таваарын хүдрийг нөөц овоолгод хуримтлуулна. Нийт олборлох 115.0 мян.тн хүдрээс 12.67 %-ийн гарцтай 14.58 мян.тн ФК-75 маркийн бүхэллэг жонш, 72.7 мян.тн ФР-40 таваарын хүдэр гаргахаар тооцлоо.

1.5. ДЭД БҮТЭЦ

1.5.1. Цахилгаан хангамж

Уурхайн цахилгаан хэрэглэгчид ба эрчим хүчний үүсгэвэр

Ил уурхайн цахилгаан хэрэглэгчид нь уурхайн тосгон, болон бусад байна.

Тосгоны хэрэглэгчид: ажилчдын байр, цайны газар.

Бусад хэрэглэгчид: засварын газар, ШТЦ, ТМ-ын агуулах.

1.5.2. Усан болон дулаан хангамж

Уурхай нь технологийн усны хэрэгцээ байхгүй бөгөөд ахуйн хэрэгцээний усыг гүний худгаас зөөврөөр хангана. Зүүн үнэгт орд нь Монгол орны усны сав газрын Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт хамаарна. Нэг хүний хоногийн хэрэгцээний усыг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07-р сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалыг үндэслэн 30 л-ээр тооцлоо. Зам талбай услах ажилд А/301 дугаар тушаалд зааснаар 1 м² талбайг услахад 2 л ус зарцуулахаар тооцлоо. Усны зардлыг эдийн засгийн хэсэгт дэлгэрэнгүй оруулж өглөө.

Уурхайн жилийн ажлын үргэлжлэх хугацаа 340 хоног тул захиргаа аж ахуйн байр, ажилчдын амрах байр зэргийг шаардлагатай үед ердийн галлагаагаар дулаан хангамжийн асуудлыг шийдвэрлэнэ. Дулаан хангамжтай холбоотой гарах зардлыг эдийн засгийн хэсэгт тусгаж өглөө.

1.5.3. Барилга байгууламж

Захиргаа үйлчилгээний объектуудад уурхайн удирдлагуудын контор (ажлын өрөө), наряд - даалгавар авах өрөө, ажилчдын хувцас солих, амрах, усанд орох байр зэрэг газрууд орно.

Эдгээр байгууламжуудыг өрөмдлөг тэсэлгээний ажлын аюулгүйн зөвшөөрөгдсөн бүсийн гадна барьж байгуулна. Уурхайн ажиллах хугацаа харьцангуй бага улирлын чанартай ажиллах зэрэгт үндэслэн барилга байгууламжийн тохижуулсан контейнер ашиглан барьж байгуулахаар төлөвлөлөө.

Шатах тослох материалын агуулах. Уурхайд жилийн дундаж хэрэглээ нь дизелийн түлшинд 356.4 тн, дизелийн масло 35.6 тн байна. Уурхай дээр байрлах шатах тослох материалын агуулах нь уурхайн 14 хоногийн хэрэгцээг бүрэн хангахаар байх шаардлагатай гэж үзэн 10 тн-ийн агуулах барьж байгуулахаар тусгалаа.

ШТМ-ын агуулахыг гал, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагын норм дүрмийн дагуу байрлуулан зориулалтын тоноглолоор хангасан байна.

Тэсрэх материалын агуулах. Уурхайд тэсэлгээний агуулах байхгүй ба өрөмдлөг тэсэлгээний ажлыг тусгай зөвшөөрөлтэй компаниар хийж гүйцэтгүүлнэ.

Автогараж. Уурхай дээр байнга ажиллах тоног төхөөрөмж нь уурхайн ачигч машин 2 шир, уурхайн дотоод тээврийн автосамосвал 6 ш, уурхайн бусад бага оврын ачааны машин 1 шир, нийт 5 орчим машин байна.

Сэлбэг материалын агуулах. Уурхайн тоног төхөөрөмжийн тоо, бүтцээс хамааруулан сэлбэг материалын агуулахын 40 тн контейнер ашиглахаар тусгалаа.

Уурхайд нийт 19 хүн ажиллахаар байна. Тус уурхайн барилга байгууламж нь үйлдвэрлэлийн барилга байгууламж ба ажиллагсдын тосгон гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ.

БҮЛЭГ II. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2.1 Сөрөг нөлөөллийг бууруулахад авсан арга хэмжээнүүд

Хайлуур жоншны ордыг олборлох үйл ажиллагааны улмаас хөрсний бүтэц, бүрэлдэхүүн, геологийн тогтоц, агаарын төлөв байдал өөрчлөгдөх, агаарын бохирдол, ландшафтын хэлбэр, байгалийн өнгө төрх өөрчлөгдөх, зэрлэг амьтад дайжих зэрэг сөрөг нөлөөллүүд дунд болон бага түвшинд байж болохын зэрэгцээ орон нутгийн дэд бүтэц сайжрах, орон нутгийн орлого нэмэгдсэнээр ядуурлын түвшинг бууруулах зэрэг нийгэм, эдийн засгийн салбарт үзүүлэх эерэг нөлөөллүүд ч байна.

Дээрх нөлөөллүүд нь тухайн бүс нутагт шууд нөлөөлөл үзүүлэхээс гадна энэ процесс нь олборлолт явагдаж байхад болон олборлолтын дараа байгаль нөхөн сэргээлт хийсний дараач сөрөг нөлөөлөл нь үргэлжилнэ. Хөх дэлийн уурхайн үйл ажиллагааны явцад ажилчдын тосгон, орд орчимд машин, техникийн хөдөлгөөн, хүний үйл ажиллагааны улмаас хөрс элэгдэх, бохирдох газрын хэвлийн хөндөгдөх явдал гарна. Энд тосгон, ил уурхайн эргэн тойрны талбай, уурхайн хооронд гарсан автозамын талбай, ил уурхайн карьер хамаарна.

Мөн уурхайгаас гарсан хүдрийг зөөж тээвэрлэх машин механизмуудад урсгал засвар, техникийн үйлчилгээ хийх, төрөл бүрийн материал сэлбэг хэрэгсэл, шингэн түлш, тос хүлээн авах хадгалах, түгээх зориулалттайгаар засварын жижиг хэсэг ажиллана.

Эдгээр үйл ажиллагааны явцаас үүсэх нөлөөллийг бууруулах, саармагжуулах үүднээс дараах арга хэмжээнүүдийн авсан болно.

Хүснэгт 5. 2022 оны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Холбогдох зардал мян.төг	Хугацаа ба давтамж	Хэрэгжүүлсэн ажлын цар хүрээ, үр дүн	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Агаар орчин	1830.0			
	Машинаас гарах тоос шороог багасгах үүднээс замын гадаргыг шаардлагатай хэсгүүдэд засах, хайрга чулуу асгаж дэвсэх	Үйл ажиллагааны зардал	3-р сар	Техникийн хөдөлгөөнөөр үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор уурхайн дотоод тээврийн 2км урттай, 6м өргөнтэй замыг 2022 оны 03-р сарын 15-наас 2022 оны 10-р сарын 15 хүртэлх хугацаанд нийт 1440м ³ ус ашигласан. Мөн уурхайн дотоод болон гадаад тээврийн зам талбайд арчилгааг тогтмол хийж, тоос дэгдэлт ихтэй хэсэгт хайрга дэвссэн. /Зураг 4/	Агаарын ба агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, MNS 0017-2-3-16:1998 (хүн ам суурьшсан хэсгүүдэд) Бензин хөдөлгүүрт MNS 5013:2003 Дизель хөдөлгүүрт MNS 5014:2003
	Уурхайн орчны авто замын тэмдэг тэмдэглэгээг засах, нэмэлтээр 1 тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах /хурд хязгаарлах/	1 тэмдэг 80.0 + ажлын хөлс = 50.0 = 130.0	3-р сар	Тээврийн хэрэгслийн хурдны хязгаарыг тогтоох зорилгоор уурхайн дотоод тээврийн гол замын эхлэлд шинээр тэмдэг байрлуулсан. Ачаатай машины дээд хурд 20 км/ц байна. /Зураг 5/	
	Шатах тослох материалын хадгалалтанд хяналт тавих, асгарч агаарт тархахгүй байлгах аргаар битүүмжтэй саванд хадгалах	Үйл ажиллагааны зардал	2022 онд	Шатах тослох материалын хадгалалтын байдлыг сайжруулан, хаягдал тос тосолгооны бүтээгдэхүүнийг гадаа задгай саванд хадгалж байсныг битүүмжтэй саванд түр хадгалж байна. /Зураг 6/	
	Хүнд механизмын хөдөлгүүрийн тохиргоо, үйлчилгээг тогтмолжуулах, хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах арга хэмжээ авах;	1,000.0	5 сард	Техникийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор тээврийн үзлэг оношилгоог цаг тухайд хийж, засвар үйлчилгээг тогтмол хийж байсан. /Зураг 7/	
	Тухайн бүс нутгийн онцлогоос хамааран ихээхэн тохиолддог цаг агаарын аюултай үзэгдэл болох хүчтэй салхи, шороон шуурга зэргийн мэдээллийг тогтмол авч олборлолтын үйл ажиллагаатай уялдуулан үйл ажиллагаагаа явуулж байх	-	2022 онд	Мандалговь цаг уурын станцын мэдээнээс үзэхэд 2000-2019 оны дундажаар: 1.Шороон шуургатай өдрийн тоо-18 2.Аадар бороотой өдрийн тоо-11 3.Хүчтэй салхитай (>=16 м/с) өдрийн тоо-60 байсан байна. Мөн 2000-2011 оны дундажаас үзэхэд цаг агаарын аюултай үзэгдэлтэй	-

“Монголросцветмет” ТӨҮГ-ын Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт байрлах “Хөх дэл”-ийн хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах төслийн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

				байсан өдрийн тоо жилд 14 өдөр байсан. Иймд бид тогтмол мэдээлэл авч дээрх цаг агаарын үзэгдэлүүдтэй уялдуулан үйл ажиллагааг зохицуулсан.	
	Хуурайшилттай үед агаарт дэгдсэн тоос шороог ус шүршиж, дэгдэлтийг дарах арга хэмжээг тодорхой хуваарийн дагуу хийж гүйцэтгэж байх	500.0	4 сард	Хаврын улиралд буюу хуурайшилт ихтэй үед өдөрт 2 удаа ус шүршиж тоосжилтыг дарсан.	-
	Дуу шуугиан ихтэй орчинд ажиллах үед ажилчдыг чихэвч болон бусад төрлийн аюулгүй ажиллагааны хамгаалах хэрэгслүүдээр шаардлагатай тохиолдолд хангах	200.0	2022 онд	Ажилчдад чихэвч болон бусад төрлийн аюулгүй ажиллагааны хэрэгслээр хангасан. /Зураг 8/	MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшний хэмжээ
2	Усны нөөц чанарыг хамгаалах чиглэлээр	500.0			
	Хайлуур жоншны ордыг олборлох үед ашиглах усны төлбөр тооцоог холбогдох байгууллагад төлөх	500.0	2022 онд	Усны нөөц ашигласны төлбөр болон ус бохирдуулсны төлбөрүүдийг тус тус төлсөн бөгөөд баримтыг хавсаргав. /Зураг 33/	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хууль ЗГ-ын 2009 оны 351 дүгээр тогтоолын хавсралт –Ус ашигласны төлбөрийн хувь хэмжээ/
	Хайлуур жоншны орд олборлолтын ажлын явцад орчны тоосжилтыг бууруулахад цэвэр усны нөөцийг аль болох ашиглахаас зайлсхийж, цэвэршүүлсэн ахуйн хаягдал усыг эргүүлж ашиглах боломжийг судлах, боломжтой бол ашиглах.	-	2022 онд	ТЭЗҮ болон БОННУ-ний нэмэлт тодотголын тайлангийн хүрээнд мэргэжлийн байгууллагаар судалгаа хийлгэж байгаа. Үүний дагуу дээрхи тайлангуудад шүүрлийн усыг ашиглах оновчтой шийдэл гаргахаар судалгааны ажил явагдаж байна.	
	Гүний худагт тоолуур суурилуулах	Үйл ажиллагааны зардал	6 сард	Гүний худагт 6 сард GERRIDA-СВК-15Х400 ⁰ С 1.6 МРА маркын тоолуур суурилуулсан болно. /Зураг 9/	
3	Хөрс, ургамлан бүрхэвч	2,000.0			

“Монголросцветмет” ТӨҮГ-ын Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт байрлах “Хөх дэл”-ийн хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах төслийн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

	Машин техникийн үйлчилгээ, засварыг тусгай бэлтгэсэн талбайд явуулж хэвших, засварын талбай, шатахуун түгээх цэг болон авто зогсоолын талбайг хатуу хучилттай болгох	1,500.0	5-р сард	Техникийн үйлчилгээ, засварыг тусгай бэлтгэсэн талбайд явуулж хэвшсэн бөгөөд засварын талбай болон авто зогсоолын талбайг шороогоор хучилт хийж сайжруулсан.	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль •Ашигт малтмал эрж хайх явцад эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн шаардлага MNS 5915:2008, •Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсийг хуулах техникийн шаардлага MNS 5916:2008, •Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага MNS 5918: 2008, •Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс MNS 4919: 2000, • Эвдэрсэн газрын хажуугийн налуу. Техникийн шаардлага MNS 4920: 2000,
	Уурхайн доторх хүнд даацын машин механизмын зам болон бусад замуудаар тогтоосон маршрутын дагуу яваагүйгээс хөрсөн бүрхэвч доройтуулж, тоосжилт үүсэх тул тогтсон хуваарийн дагуу тээвэрлэлтийг явуулах, хэт хурдтай явуулахгүй байх арга хэмжээ авах	-	2022 онд	Тээврийн хэрэгслийн хурдны хязгаарыг тогтоох зорилгоор уурхайн дотоод тээврийн гол замын эхлэлд шинээр тэмдэг байрлуулсан. Ачаатай машины дээд хурд 20 км/ц байна. /Зураг 5/ Мөн тээвэрлэлтийн тогтсон хуваарийн дагуу хийж гүйцэтгэж байна.	
	Карьерт хүн, мал, ан амьтан унахаас сэргийлэх арга хэмжээ авах /хашаа, хаалт нэмэлтээр хийж өгөх/	400.0	5-р сард	Уурхайн карьерт хүн, мал, унахаас сэргийлж эвдэрсэн хашааг завсарлан, эрсдэлтэй нүхийг тойруулан овоолго үүсгэсэн. /Зураг 10/	
	Хэрэв шатах тослох материалын хадгалалтын явцад асгарч гойжвол тухай бүрд нь элс, даавуу зэрэгт шингээн авч галын аюулгүй нөхцөлд ариутгах зэргээр цаг алдалгүй хөрсийг цэвэрлэх	100.0	2022 онд	2022 оны үйл ажиллагааны явцад шатах тослох материал асгараагүй болно. Хэрэв асгарсан тохиолдолд авах арга хэмжээг ажилчдад заасан болно.	-
4	Ан амьтан	250.0			
	Уурхайн ухаш, мөргөцөгт үргэж дайчсан, зэрлэг ан амьтан орж гэмтэх, үрэгдэхээс сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх, шувууны үүр хийж байршуулах	150.0	2022 онд	Шувуудыг хамгаалах зорилгоор 4 ш шувууны үүр хийж 2ш-ийг суманд хүлээлгэн өгч 2ш-ийг төслийн талбай орчимд байршуулсан. /Зураг 11/	Амьтны тухай хууль
	Уурхайн ажиллагсадад зэрлэг ан амьтадыг үргээх хууль бусаар агнахыг хориглох	-	2022 оны турш		
	Шувууны хиймэл үүр болоод суугч хийх	100.0	2022 онд		-
	Нийт зардлын хэмжээ /мян.төг/	6 580.0			



Зураг 4. Тоосжилт дарах зорилгоор зам арчилгаа хийсэн байдал

“Монголросцветмет” ТӨУГ-ын Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших “Хөх дэл”-ийн хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах төслийн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



Зураг 5. Хурдны хязгаарлах тэмдэг байрлуулсан байдал



Зураг 6. Шатах тослох материалын хадгалалтыг сайжруулсан байдал

Дээрх зураг 6-д харуулснаар шатах тослох материалын хадгалалтыг эхний зурагт харагдаж буй байдлаар гадаа байсныг нар тусахгүй газар, битүүмжтэй саванд түр хадгалж байна.




Зураг 7. Авто тээврийн хэрэгслүүдийг үзлэгт хамруулсан байдал /Бас зураг 32-т/



Зураг 8. Ажилчдын байдал ХХАА-ны хувцас хэрэглэл



Зураг 9. Гүний худагт суурилуулсан тоолуур



**Зураг 10. Уурхайн карьерт мал, амьтан унахаас сэргийлж нүхийг тойруулан овоолго
үүсгэсэн байдал**



Зураг 11. 2ш шувууны үүр хийж байрлуулсан байдал


2.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг Монгол улсын Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 03 дугаар сарын 30 –ны өдрийн А-138 дугаар тушаал “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”-ын дагуу гүйцэтгэж нөхөн сэргээлтэнд гарах зардлыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны сайд, Эрдэс баялаг, эрчим хүчний яамны сайдын хамтарсан 2010 оны 05 сарын 17-ны өдрийн А-132/112 дугаар тушаалын хавсралтын дагуу хийж гүйцэтгэсэн.

Хүснэгт 6. 2022 оны техник болон биологийн нөхөн сэргээлтийн төлөвлөлтийн биелэлт



№	Үзүүлэлт	Ажлын хэмжээ	Зардал мян.төг
Техникийн нөхөн сэргээлтийн арга хэмжээ			
1	Техникийн нөхөн сэргээлт - 2022 онд техникийн нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд 1-р хүдрийн биет дээрх 520м ³ овоолго, 5-р хүдрийн биет дээрх 650м ³ хуучин карьерын овоолгуудыг тус тус тэгшилж нөхөн сэргээнэ. Энэхүү ажлын үр дүнд 80м ³ талбай чөлөөлөгдсөн. /Зураг 12/	1170м ³ талбайд нөхөн сэргээлт хийж нөхөн сэргээлтийг орон нутагт хүлээлгэн өгч акт гаргасан. /Зураг 13, 14/	Ашиглалтын зардал
Биологийн нөхөн сэргээлт			
2	Биологийн нөхөн сэргээлт - 2022 онд биологийн нөхөн сэргээлт хийгдэхгүй бөгөөд Баянжаргалан сумаас ирүүлсэн чиглэлийн дагуу дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд 500 мод тарина.	Уурхайн кемпийн хашаанд болон уурхайн дотоод тээврийн гол зам дагуу нийт 0.5 га газарт 500 ш хайлаас мод тарисан. /Зураг 12, 15, 16, 17, 18/	-
			-

“Хөх дэл”-ийн хайлуур жоншны ордын 2022 онд Биологийн нөхөн сэргээлт болон дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний талбайн байршлын зураг



Зураг 12. Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайн зураг

“Монголросцветмет” ТӨҮГ-ын Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших “Хөх дэл”-ийн хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах төслийн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан




Зураг 13. Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайн зураг

2.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 7. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Хамгааллын арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал (мян. төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хөтөлбөр боловсруулах	2022 онд хийлгэж буй БОННУ-ний нэмэлт тодотголын ажлын хүрээнд дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг төлөвлөх, газрыг сонгох ажлын мэргэжлийн байгууллагаар боловсруулуулж байна.	-	-	БОНБУ-ний тухай хууль: 3.1.11, 8.4.6, 9.6 - Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам: ЗГ-ын 2013 оны 374 дүгээр тогтоолын 2-р хавсралт-5.2 зүйл
Төлөөлүүлэн хамгаалах газрын байршлыг орон нутгийн захиргаатай хамтран төлөвлөх, саналыг нь тусгаж, хамгаалалтад авах				
Баянжаргалан сумын ЗДТГ-аас өгсөн чиглэлийн дагуу 2022 оны дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд “Тэр бум мод” төсөлд хамрагдан мод тарих ажлыг зохион байгуулахаар төлөвлөсөн. Бид “Тэр бум мод” төслийн хүрээнд 500 ш мод тарихаар төлөвлөж байна. Энэхүү бүс нутаг нь хуурай, цөлөрхөг уур амьсгалтай тул тухайн уур амьсгалын онцлогт таарсан, цөлжилтийг тодорхой хэмжээгээр бууруулах улиас, хайлаас гэх моднуудыг тарина.	Уурхайн кемпийн хашаанд болон уурхайн дотоод тээврийн гол зам дагуу нийт 0.5 га газарт 500 ш хайлаас мод тарисан. /Зураг 13, 14, 15/	5 000.0	2022 он	
		5 000.0		



Зураг 14. Техникийн нөхөн сэргээлт хийж овоолгуудыг тэгшилсэн байдал



Зураг 15. Хайлаас мод тарьж буй байдал /уурхайн кемп дэх талбайд/



Зураг 16. Хайлаас мод тарьж буй байдал /уурхайн кемп дэх талбайд/



Зураг 17. Хайлаас мод тарьж буй байдал /уурхайн гол зам дагуу/



Зураг 18. Хайлаас мод тарьсан байдал

2.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Уг төсөл маань Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутаг дэвсгэрт харьяалагддаг бөгөөд төслийн талбайд айл өрх суурьшаагүй учраас нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох асуудал үүсэхээргүй байна.

2.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн талбай болон түүний нөлөөлийн бүсэд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл ба археологийн олдвортой газар байхгүй. Төслийн хэрэгжилтийн явцад ямарваа нэгэн түүх соёлын дурсгалт зүйл олдох үед холбогдох хууль тогтоомжид заасны дагуу засаг захиргааны байгууллага болон холбогдох байгууллага болох ШУА-ийн түүх, археологийн хүрээлэнд даруй мэдэгдэж төслийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсооно.

2.6. Болзошгүй эрсдлээс хамгаалах менежментийн төлөвлөгөөний биелэлт

Уурхайн жонш олборлолтын үйл ажиллагаанд ямарваа нэг химийн бодис ашигладаггүй нь химийн бодисоос үүсэх эрсдэлгүй болж байгаа тул болзошгүй эрсдлээс хамгаалах төлөвлөгөөг боловсрууллаа. Төсөл хэрэгжих талбай болох Баянжаргалан сумын нутаг дэвсгэрт байгалийн аюулт үзэгдэлүүд тохиолдох магадалал өндөртэй. Тухайлбал хүчтэй шороон шуурга жилд дунджаар 10-30 өдөр бол цасан шуургатай өдрийн тоо 5 байсан дундаж үзүүлэлттэй байна. Мөн уурхайн олборлолтын үйл ажиллагааны үед ажилчдын анхаарал болгоомжгүйгээс ажилчид бэртэж гэмтэх, шатах тослох материал алдагдах үед галын аюул эрсдэл үүсэх боломжтой.

Хүснэгт 8. Болзошгүй эрсдлээс хамгаалах төлөвлөгөөний биелэлт

Арга хэмжээ	Эрсдлээс хамгаалах арга хэмжээ	Төсөв /мян.төг/	Хугацаа ба давтамж	Хэрэгжүүлсэн ажил	Гарах үр дүн
Эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Болзошгүй эрсдлээс хамгаалсан сургалт зохион байгуулах	-	6-р сар	Сургалтыг нийт 8 ажилчдад зохион байгуулсан. /Зураг 19/	Эрсдлээс сэргийлэх
Эрсдэл тохиолдох үед авах арга хэмжээ	Аюул тохиолдсон газрыг хамгаалалтанд авч, хор аюулын таних тэмдэглэгээг байршуулж холбогдох мэргэжлийн байгууллагыг дуудан туслалцаа авах	-	Ашиглалтын явцад	-	Эрсдлийг бууруулах
Эрсдэл тохиолдсон ы дараах үед авах арга хэмжээ	Хяналт, мониторинг хийлгэх, эрсдлийн төлөвлөгөө боловсруулах	300.0	-	Аваар устгах төлөвлөгөө боловсруулж, мөрдөн ажиллаж байна.	Дүгнэлт гаргах
Нийт төсөв /мян.төг/		300.0			



Зураг 19. Болзошгүй эрсдэл болон аюул ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор ажилчдад сургалт зохион байгуулж буй зураг

2.7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хог хаягдлын хяналт, удирдлага, зохион байгуулалт

Хайлуур жоншны ордын ашиглалттай холбогдож гарах хог хаягдлын хяналт, удирдлага, зохион байгуулалтыг оновчтой шийдвэрлэх зорилгоор журам боловсруулж мөрдөнө. Уг зорилтын хүрээнд хог хаягдал, байгаль орчны талаарх Монгол Улсын хууль, бодлого шийдвэр, дүрэм журмын дагуу, Олон улсын уул уурхайн үйл ажиллагаанд шалгарсан дэвшилтэт арга технологиудыг судална. Энэ талаарх тайлбарыг хаягдлын төрөл тус бүрээр доор оруулав.

Хог хаягдлыг цэвэрлэх, зайлуулах арга хэлбэр:

Тус уурхайн олборлолтын үйл ажиллагаанаас гарах технологийн хатуу хог хаягдал нь олборлолтын явцаас гарах нарийн ширхэгт хөрс, шороо. Тус хаягдлыг уурхайн нөхөн сэргээлтэд эргүүлэн ашиглана. Үйлдвэрийн гаралтай металл хаягдлыг тусгай талбайд хурааж, тээвэрлэж, 2-догч түүхий эд болгон борлуулах арга хэмжээг авна.

Мөн ажиллагсдын байрлах байрнаас хатуу хог хаягдал гарна. Үүнийгээ тусгай зориулалтын тагтай саванд хадгалж байгаад тээвэрлэн сумын захиргаатай гэрээ байгуулан тогтмол хугацаанд заасан хогийн цэгт зайлуулна. Ахуйн хаягдал цуглуулах цэгийн ашиглалтыг сайжруулах, хашаалах, хуучин хаягдлын нүхийг дарж булж, овоолго шороог нэгтгэж эмхэтгэх.

Шингэн хаягдал цэвэрлэгээ, арга хэлбэр, зайлуулалт:

Ахуйн шингэн хаягдлыг тусгай бэлтгэсэн нүхэнд хаяхын зэрэгцээ бие засах газрыг эрүүл ахуйн талаас нь стандартын шаардлага хангахуйц бетонон доторлогоо хийх, засаж тохижуулж үнэр болон бусад сөрөг нөлөөлөл үүсэхээс урьдчилан сэргийлж байгуулах болно.

Хүснэгт 93. Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний биелэлт

Хог хаягдлын төрөл	Арга хэмжээ	Жилд гарах хэмжээ	Төсөв /мян.төг/	Хугацаа ба давтамж	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Гарах үр дүн	Стандарт
Хатуу хог хаягдал	Түүхий эдийн хог хаягдлыг тараахгүй байлгах	-	-	2022 оны турш	Түүхий эдийн хаягдал үүсээгүй болно.	Талбайн тархалтыг бууруулах	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Хаягдал усыг зайлуулах цэг тогтоох журам, Ариун цэврийн тухай хууль
	Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний явцад гарсан аюултай хог хаягдлыг контейнерт хадгалах /аккумулятор, баттерей Ашиглагдсан шатах тослох материал, тос маслын сав г.м./	Бүртгэл хөтөлж хаягдлын хэмжээг гаргана.	-	Сар бүр	Аюултай хог хаягдлыг хадгалах контейнер байрлуулсан. /Зураг 20/ Манай уурхайн хэмжээнд машин механизм цөөхөн тул хаягдал дугуй, төмрийн хэмжээ бага байна.	Эрсдлээс хамгаалах	
Шингэн хог хаягдал	00 -ын цэгийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, засаж тохижуулж байх		-	7-р сард	00-ын байгууламжийг эр, эм-ээр ялгаж сайжруулсан. /Зураг 21/	Бохирьг хөрсөнд нэвчихээс хамгаалах	
	Ариутгал, халдваргүйжүүлэлтийг хийх	3 м ³	2 удаа * 60.0 = 120.0	Жилд 2 удаа	Уурхайн 00-ын цэг, хог хаягдлын цэг болон бохир усны цооног зэргийг 2 удаа халдваргүйжүүлэн ариутгасан. /Зураг 22/	Бохирдлоос хамгаалах	
	Ахуйн бохир усыг Ажилчдын хотхоны дэргэд байх түр цооногт хадгалах	-	-	-	Ахуйн бохир усыг доторлогоотой цооногт түр хадгалж байна. /Зураг 23/	Бохирдлоос хамгаалах	
	Ашиглагдсан шатах тослох материалыг битүү саванд хадгалж байгаад дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлнэ.	-	-	2022 он	Шатах тослох материалын хадгалалтын байдлыг сайжруулан, битүүмжтэй саванд түр	Бохирдлоос хамгаалах	

“Монголросцветмет” ТӨҮГ-ын Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших “Хөх дэл”-ийн хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах төслийн 2022 оны
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

					хадгалж байна. /Зураг 6/	
Ахуйн хог хаягдал	Шаардлага хангасан цэгт төвлөрүүлж орон нутагтай хог ашиглалтын гэрээ хийж зайлуулна.	2тн	-	2022 он	Хог хаягдыг гэрээг орон нутагтай хийсэн. /Зураг 25/	Салхинд хийсэхээс хамгаалах
	Ахуйн хог, хаягдлыг түр хадгалах зориулалтаар дахин ашиглагдах, ашиглагдахгүй байдлаар нь ангилан хадгалах 3-аас дээш тасалгаатай хогийн сав болон бетонон суурьтай хогийн цэг бий болгох, хогийн цэгийг хаших, тэмдэгжүүлэх (зонхилох салхины чиглэлийн доор, аливаа объектоос доод тал нь 60м-ийн зайд),		400.0	8 сард	Ахуйн хог хаягдлыг ангилан хаяж байх зорилгоор 3ш хогийн сав авч уурхайн кемпд байрлуулсан. /Зураг 24/	Бохирдлоос хамгаалах
Нийт төсөв /мян.төг/			520.0			



Зураг 20. Аюултай хог хадгалах байр



Зураг 21. 00-ыг сайжруулсан байдал





Зураг 22. Ариутгал, халдваргүйжүүлэх ажил хийгдэж буй байдал



Зураг 23. Ахуйн бохир усыг түр хадгалах цооног



Зураг 24. Ахуйн хог хаягдлыг ангилан хаях хогийн сав

ХОГ ХАЯГДЛЫН ГЭРЭЭ		
2022 он ... сарын ... өдөр	№ ...	Баянжаргалан сум
Нэг. Нийтлэг үндэслэл		
<p>Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17-р зүйлийн 2.6 дахь заалт, Хог хаягдлын тухай хуулийн 8.4, 9.2, 20.1, 20.2 дугаар зүйл, Сумын ИТХ-ийн 2019 оны 05 тоот тогтоолыг үндэслэлээ.</p> <p>Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах түүнээс урьдчилан сэргийлэх ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, дахин боловсруулж эргүүлэн ашиглах, тээвэрлэх булах болон орчны ариун Цэврийг тогтмол цэвэр байлгах, цэвэр эрүүл орчинд ажиллаж амьдрах орчныг бий болгоход оршино.</p>		
Хоёр. Гэрээ байгуулагч талууд		
<p>Нэг талаас Дундговь аймгийн Баянжаргалан сумын ЗДТГ-ыг төлөөлж Энгэр ус 2-р багийн Засаг дарга Э.Дашдамба; Нөгөө талаас “Дундговь Баянжаргалан сумын 2-р багт орших Хөх дэлийн уурхайд үйл ажиллагаа явуулж буй 9011004051 тоот улсын бүртгэлийн дугаартай, 5002109 тоот регистрийн дугаартай “Флюмон” ХХК-ийн захирал Дамба овогтой Нансалмаа нар харилцан тохиролцож 2022 оны 04 сарын 05-ны өдрөөс 2023 оны 04 сарын 05-ыг хүртэл 1 жилийн хугацаатай энэхүү гэрээг байгуулав.</p>		
Гурав. Төлбөр тооцон байдал		
<p>Баянжаргалан сумын 2019 оны 12 дугаар сарын 19-ны ИТХ-ын 05 тогтоолд заасны дагуу сард 80'000 төгрөгөөр тооцов.</p> <p>Жилийн төлбөр 960,000 төгрөг</p>		
Дөрөв. Сумын ЗДТГ-ын эрх		
<ol style="list-style-type: none">1. Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хог хаягдлын хууль, Ариун цэврийн тухай хуулийн дагуу хяналт тавьж ажиллах2. Иргэд аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдал гаргасны төлбөрийг төвлөрүүлэх3. Иргэд аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлаа зориулалтын цэгт хаяж байгаа эсэхэд хяналт тавих4. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх хуваарийг тээвэрлэлтэй гэрээ байгуулж хэрэгжилтэд хяналт тавих.		
Тав. Иргэн ААН байгууллагын эрх үүрэг		
<ol style="list-style-type: none">1. Өөрийн байгууллагын үйл ажиллагаанаас гарсан ахуйн хуурай хог хаягдлыг стандартын шаардлага хангасан зориулалтын саванд хадгалж байх.		
2. ААН байгууллага нь хог хаягдал гарсан төлбөрөө улрал бүрийн сүүл сарын 15-ны дотор Дундговь аймгийн Баянжаргалан сумын татварын байцаагчтай холбогдож хог хаягдлын төлбөрөө төлөх.		
3. Хог хаягдлыг ангилан ялгаж байх.		
4. Ахуйн болон үйлдвэрлэлийн хогийг тогтсон хугацаанд цэвэрлэх тээвэрлэх, хог хаягдлын талаарх дүрэм журам, стандартын шаардлагыг хангах зориулалтын цэгт хаяж байхад анхаарах.		
5. Үйлдвэр үйлчилгээний явцад үүсдэг хог хаягдлын хэмжээ, бусад мэдээллийг сумын захиргаанд мэдээлж байх.		
6. Хог хаягдлыг ангилан хаях талаарх мэдээллийг ажилтнуудад эзэмшүүлэх, сургалт сурталчилгаа явуулах, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллах.		
7. Оршин суугаа газар орчмын хог хаягдлыг цэвэрлэх, олон нийтийг хамарсан ажилд оролцох.		
8. Хуульд заасан журмын дагуу олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх, хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг эрх бүхий байгууллага албан тушаалтнаас шаардах.		
9. Үүссэн аюултай хог хаягдал, түүний эх үүсвэрийн талаар төрийн болон нутгийн захиргааны байгууллагад мэдээлэх.		
10. Дундговь аймгийн Баянжаргалан сумын татварын байцаагчтай холбогдож хог хаягдлын төлбөрөө төлөх		
Зургаа. Гэрээний хариуцлага		
<ol style="list-style-type: none">1. Аж ахуй нэгж байгууллага нь хог хаягдал гаргасны төлбөрөө удаан хугацаагаар төлөөгүй болон ил задгай хог шатаасан, зориулалтын бус газар хог хаягдал хаясан нөхцөлд өр авлагыг барагдуулах ба учруулсан хохирлыг арилгах шаардлагатай тохиолдолд холбогдох дээд шатны байгууллагад хандан хог хаягдлын тухай хуулийн дагуу хариуцлага тооцно.2. Аж ахуй нэгж байгууллага нь энэхүү гэрээнд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл хоёр талын хамтарсан төлөөлөгч тухай бүр шийдвэрлэнэ.		
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН		
<p>ДУНДГОВЬ АЙМАГ БАЯНЖАРГАЛАН СУМ Энгэр ус 2-р багийн Засаг дарга: Э. Дашдамба Утас: 94114949</p>	<p>ФЛЮМОН ХХК-ийн Захирагч Д.Нансалмаа Утас: 98080090, 99151969</p>	

Зураг 25. Хог хаягдлыг гэрээ

Татвар төлбөр

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК- Most Money Татвар төлөлт		Огноо: 2022-11-22 12:17	
Гүйлгээний дугаар		№ : 121964355	
Хүлээн авагч:	Дундговь	Хүлээн авсан данс:	100080500947
Төлөгч РД:	75000856398	Гүйлгээний суваг:	IPhone
Биллийн дугаар:	2221102543659		
Татварын мэдээлэл			
Эзэмшигч:	Дундговь аймгийн Баянжаргалан сумын засаг даргын тамгын газар	Татварын төрөл:	Хог хаягдлын үйлчилгээний хураамж
Утас:		Тайланг хугацаа:	2022
	Харенгийн дугаар:	Төлөх дүн:	960000
Төлбөр хийсэн данс : MN950019009000014750		Нийт төлсөн дүн : 960000	
Гүйлгээний утга : 2221102543659 75000856398 Дундговь аймгийн Баянжаргалан сумын засаг даргын тамгын газар MN950019009000014750			
Татвараа хугацаанд нь төлсөн танд баярлалаа. Татвартай холбоотой асуудал байвал дараах хаягаар хандана уу! 1800-1288, INFO@MTA.MN.			
Хянасан :	Теллер :	Харилцагч :	

Зураг 26. Хог хаягдлын төлбөр төлсөн баримт


2.8. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

№	Авах арга хэмжээ	Хугацаа, давтамж	Урьдчилсан зардал, мян.төг	Хэрэгжүүлсэн ажил	Гарах үр дүн
1	Мэргэжлийн байгууллагатай хамтран хөдөлмөр хамгаалал, байгаль орчныг хамгаалах, гал түймрээс урьдчилсан сэргийлэх талаар сургалт, сурталчилгааг ажилчдад хийх	2022 онд	1удаа*10 хүн * 10.0=100.0	Нийт 15 ажилчдад энэхүү сургалтыг хийсэн. /Зураг 19/	Ажилчдын байгаль орчны боловсролыг дээшлүүлж, хувь хүнээс үүдэлтэй бохирдлыг бууруулах
2	Байгаль хамгаалахад иргэдийн оролцоог идэвхжүүлэх, уулзалт зөвлөгөөг жил бүр зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОХТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах	11-р сард	100.0	12-р сард БОМТөлөвлөгөөнд иргэдийн санал хүсэлтийг тусгах болон 2022 онд хийсэн ажлыг тайлагнасан. /Зураг 39/	
3	Байгаль орчныг хамгаалах, хог хаягдлаа тогтоосон цэгт хаях, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар сурталчилгааны самбарыг уурхайн кэмп, төв хаалга, уурхайлалтын бүсэд байрлуулах	2022. онд	3ш самбар*50.0=150.0	Уурхайн орчимд 3 ширхэг самбар байрлуулсан ба уурхайн кэмп, ажилчдын сууцанд байгаль дэлхийгээ хайрлах болон усаа гамтай хэрэглэх, аюулгүй ажиллагаа талаарх самбарууд байрлуулсан. /Зураг 27, 21/	
4	Галын аюулгүй байдлын дүгнэлтийг аймгийн Онцгой байдлын хэлтсээр гаргуулах	2022 онд	-	Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулсан. /Зураг 36/	
	дүн		350.0		



Зураг 27. Байгаль дэлхийгээ хайрлах талаар ухуулга самбарыг шувууны үүртэй хамт хийсэн байдал



Зураг 28. Аюулгүй ажиллагааны самбар байрлуулсан байдал

2.9. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “Монголросцветмет” ТӨҮГ-аас явуулж байгаа үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан чухал баримт бичиг юм.

Энэхүү орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн зардлыг гаргахдаа ЦУОШГ, Байгаль орчин, хэмжил зүйн төв лаборатори, Геологийн төв лаборатори, ШУА-ийн Геоэколийн хүрээлэнгийн хөрсний лабортори, хөрсний хортой хүнд хортой элементийг “Ханлаб” ХХК -ийн лаборотори болон ШУА, Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн усны шинжилгээний лабораторид мөрдөгдөж буй үнийг үндэслэн зардлын тооцоог гаргав.

Хүснэгт 11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийсэн байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
Агаарын чанар						
1.1	Агаарын бохирдол, тоосжилтын шинжилгээ хийлгэх	Уурхайлалт явагдаж буй талбайд	Төсөл хэрэгжих талбайд хяналтын 2 цэг сонгох зонхилох салхины доод ба дээд талд -Уурхайн карьерт -Уурхайн ажилчдын байр орчимд тус тус агаарын шинжилгээ хийсэн. /Зураг 34/ Стандарт үзүүлэлтээс давсан үзүүлэлт байхгүй.	Жилд 1 удаа	60.0 х 2 цэг х жилд 1 удаа Нийт – 120.0	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга, MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга
1.1	Цаг уурын үзүүлэлтүүдийн сумын харуулын, станцаас авах /Температур харьцангуй чийг, даралт, салхины хурд ба чиглэл, хур тунадас, шороон шуургатай өдөр/	Уурхайн орчимд	Мандалговь цаг уурын станцаас мэдээ авсан. Тайлбар хэсгээс харна уу.	Жилд 1 удаа	100.0 1 жилийн мэдээ худаладан авах	Тайлбар: Мандалговь цаг уурын станцын мэдээнээс үзэхэд 2000-2019 оны дундажаар: 4.Шороон шуургатай өдрийн тоо-18 5.Аадар бороотой өдрийн тоо-11 6.Хүчтэй салхитай (>=16 м/с) өдрийн тоо-60 байсан байна. Мөн 2000-2011 оны дундажаас үзэхэд цаг агаарын аюултай үзэгдэлтэй байсан өдрийн тоо жилд 14 өдөр байсан. Иймд бид тогтмол мэдээлэл авч дээрх цаг агаарын үзэгдэлүүдтэй уялдуулан үйл ажиллагаа зохицуулсан.
Хөрсний бохирдол						


“Монголросцветмет” ТӨҮГ-ын Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших “Хөх дэл”-ийн хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах төслийн 2022 оны
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

